

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-5

**1.Дэд хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг
байгуулах тухай/ 3-5**

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны
4 дүгээр сарын 27-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны дарга Ч.Анар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 7 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 21 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Тасалсан: Р.Батболд, Х.Булгантуяа, С.Цэнгүүн;

Нэг. Дэд хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт Х.Шижирмөнх байлцав.

Дэд хорооны дарга Ч.Анар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ч.Анар: “Ажлын хэсэг байгуулах тухай” дэд хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэд хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, Ж.Золжаргал, Л.Соронзонболд, Д.Пүрэвдаваа нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 08 минут үргэлжилж, 7 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр 14 цаг 29 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА

Ч.АНАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
14цаг 21 минут.*

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ч.Анар: Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Цэндийн Баатархүү, Пүрэвжавын Ганзориг, Батбаярын Жаргалан, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Чинбаатарын Анар гишүүд ирж, ирц 62.5 хувьтайгаар өнөөдрийн ирц бүрдсэн тул дэд хорооны 26 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Дэд хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Ажлын хэсэг байгуулах тухай асуудлыг хэлэлцэнэ.

Ажлын хэсэг нь 2025 онд Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 6 тоот тогтоолоор Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад олон талт хэрэгцээ шаардлагад нийцсэн, үр өгөөжтэй, ашиглах боломжтой хиймэл дагуулын талаар судлах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж ажилласан. Ажлын хэсгийн тодорхой хугацаанд ажиллаж санал, дүгнэлтүүд гаргасан.

2025 оны Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт орсон өөрчлөлтийн дагуу Инновац, цахим бодлогын байнгын хороо татан буугдаж чиг үүрэг Эдийн засгийн байнгын хороонд шилжсэн.

Үүнтэй холбогдуулаад энэхүү ажлын хэсгийг дэд хороон дээр шинэчлэн байгуулж санал, дүгнэлтээ танилцуулах шаардлагатай гэж үзсэн байгаа юм. Энэ учраас одоо байгаа ажлын хэсэг дүгнэлтээ гаргахын тулд дэд хорооны доор байгуулагдах шаардлагатай болж байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой өөр саналтай гишүүд байна уу?

Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

1.Ажлын хэсэг байгуулах тухай, хэлэлцэх асуудал дээр ажлын хэсгийн талаарх товчхон дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч миний бие танилцуулъя.

Та бүхэн мэдэж байгаа 2024 онд орж ирсэн хиймэл дагуулын төсөл маань өөрөөр хэлбэл Их Хурал дээрээс, төсөв дээрээс буцсан байгаа. Инновац, цахим бодлогын байнгын хороон дээр гарч ирсэн ажлын хэсэг бол энэ хугацаанд 5, 6 уулзалтуудыг хийсэн байгаа. Та бүхэнд танилцуулгууд тараагдсан байгаа.

Монголын хүсэлтийг албан ёсоор тараагдаж хүсэлт баталгаажуулсныг баталгаажуулсан.

Мөн 2025 оны 3 сарын 27-нд ажлын хэсэг Парис хотод “Thales Alenia Space”-тэй уулзаж техникийн болон эдийн засгийн хэлэлцээрт шаардлагууд тавигдсан. Нийт нэн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 15 хувь байсныг нь 100 хувь болгохоор хэлэлцээрийн шаардлагыг тавьсан.

Хоёрдугаарт, үнэ өртгийг бууруулах шаардлага тавигдсан. Мөн тандан судалгааны хиймэл дагуулын шаардлагуудыг өгсөн. Тэгэхээр тодорхой хэмжээнд “Thales Alenia Space” дээрээс бол бид нарын ажлын хэсгээс тавигдсан шаардлагуудыг бол хүлээн авч, 2025 оны 10 сард бол албан ёсоор зохих хариунуудыг Сангийн яам, Гадаад хэргийн яам, Цахим, харилцаа холбоо, хөгжлийн яам дээр ирүүлсэн байгаа.

Энэ хугацаанд ажлын хэсэг бусад үндэсний хиймэл дагуул хөөргөх, өндөр орбитын хиймэл дагуул хөөргөх компаниудтай уулзалт хийсэн. Энэ хүрээндээ Оросын Холбооны Улсын “Sistema” групп, Америкийн Нэгдсэн Улсын “Astranis”, Францын “Kratos” групптэй хийсэн уулзалтууд, Америкийн “Viasat”, мөн Сингапур улсын хиймэл дагуул хөөргөх “broadband network” гэсэн компаниудтай уулзалт хийсэн та бүхэнд танилцуулга тараагдсан байгаа. Энэ хурлуудаар хийгдээд ажлын хэсэг бол дүгнэлтээ гаргахад бэлэн болсон байна.

Ажлын хэсэг байгууллагатай холбогдолтой болон ажлын хэсгийн тараагдсан материалтай холбогдолтой асуулт асуух гишүүд байвал саналаа, нэрсээ өгнө үү.

Асуулт асуух хүн алга.

Ажлын хэсэг байгууллагатай холбогдолтойгоор санал хураалт явуулж эхэлье.

Ажлын хэсгийн тогтоол тараагдсан байна. Ажлын хэсгийн тогтоолыг танилцуулъя та бүхэнд.

Монгол Улсын Их Хурлын дэд хорооны тогтоол “Ажлын хэсэг байгуулах тухай”,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийг үндэслэн Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооноос тогтоох нь:

1.Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад үр өгөөжтэй ашиглах боломжтой олон талт хэрэгцээ шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар судлан санал, дүгнэлт боловсруулж дэд хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Анар Их Хурлын гишүүн.

Ажлын хэсгийн гишүүд: Ж.Золжаргал, Д.Пүрэвдаваа Ж.Баярмаа, дэд хороон дээр.

Хоёрдугаарт, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр эрдэмтэн, судлаач, шинжээчид, холбогдох

байгууллагын албан хаагчдыг татан оролцуулахыг ажлын хэсгийн дарга Ч.Анар-д зөвшөөрсүгэй.

Инновац, цахим бодлогын хөгжлийн хорооны дэд дарга Анар гэсэн байна.

Энэ дэд хорооны тогтоол ажлын хэсэгт дэд хорооны гишүүдээс оролцох боломжтой байгаа. Ажлын хэсэгт шинээр нэгдэж орох дэд хорооны гишүүд байна уу? Энэ бол нөгөө хуучин Байнгын хороон дээр гарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнээрээ байгуулагдаж байгаа. Үүнээс боловсрогдсон дүгнэлт нь Эдийн эдийн засгийн байнгын хороонд танилцуулагдаад Их Хурлаар ороод Засгийн газарт чиглэл өгөх тогтоол гарах болно. Ажлын хэсэгт орох гишүүн байна уу?

Соронзонболд гишүүн. Соронзонболд гишүүн ажлын хэсэгт орохоор боллоо.

Тэгэхээр ажлын хэсэг дотор протокол дээр нэмье Соронзонболд гишүүн. Байнгын хорооны ажлын хэсэгт бол Ж.Золжаргал, Д.Пүрэвдаваа, Ж.Баярмаа нарын гишүүд бол манай дэд хорооны гишүүн биш. Гэхдээ Их Хурлын тухай хуулийн 8.1.7-д заагдсаны дагуу хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал Байнгын, дэд хорооны ажлын хэсэгт хүсэлтээрээ, эсвэл томилсны дагуу орж ажиллах гэсэн заалтын дагуу эдгээр гишүүд маань өөрсдийн хүсэлтээ албан ёсоор ирүүлж ажлын хэсэгт орж байгаа болно.

Энэ тогтоолын төсөлтэй холбогдуулаад санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдье. Бэлдчихсэн үү? Ажлын хэсэг байгуулахыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Ажлын хэсэг байгуулахыг 80 хувийн саналаар нийт ирцэд орсон гишүүд дэмжсэн тул ажлын хэсэг байгуулагдлаа.

Өнөөдрийн дэд хорооны хуралдаан дууссаныг мэдэгдье. Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны өнөөдөр хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Ажлын хэсэг болон хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүдэд баярлалаа.

14.29 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

